


ПАРЛАМЕНТ ГЭЖ ЮУ ВЭ?

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Найзүүд аа! Парламентын талаар мэдэхийн тулд бүгдээрээ цаг хугацаагаар аялцгаая!




1200-аад оны Англи улс. Энэ үед Английн эзэн хаан бүхний ЭЗЭН байжээ. Тэр хуулиас ч дээгүүр эрх мэдэлтэй байв.

Английн эзэн хаан Жон өөрийгөө хуулиас дээгүүр гэж үздэг байсан бөгөөд бүхнийг өөрийн хүслээр шийддэг байжээ. Түүнийг "Английн хамгийн мүү эзэн хаан" байсан гэж үздэг.



Энэ хааныг бид "Робин Гуд" хүүхэлдэйн киноны Жон хаанаар мэднэ. Ард олноос маш их татвар авч, өөрийн эсрэг тэмцсэн хүмүүсийг шоронд суулгаж, тамладаг харгис хаан байжээ.



Жон хаан Франц улстай олон удаа дайн хийж, цэрэг армидаа зориулж баронууд буюу газрын эзэд мён ард иргэдээс маш их хэмжээний татвар авдаг байжээ.

Жон хааны цэрэг Францын цэргүүдэд байнга ялагддаг байв.




Газрын эзэд Жон хааны хязгааргүй эрх мэдлийг эсэргүүцэж тэмцэл өрнүүлжээ. Тэмцлийн дунд Жон хаан газрын эзэд аргагүйн эрхэнд бууж өгч, тэдний шаардлага бүхий баримт бичигт гарын үсэг зуржээ. Ингээд хааны хэмжээлшгүй эрх мэдлийг хязгаарлах тухай Магна Харта буюу Их цааз гэх баримт бичиг 1215 онд гарсан түүхтэй.




Магна Харта бол одоо бидний мэдэх ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааны эхлэл болсон баримт бичиг юм.

〔МАГНА ХАРТЫГ БАТАЛСНААР:〕

- Хааны эрх мэдлийг хязгаарлажээ. Хаан хүссэн болгоноо өөрийн дураар хийх эрхгүй болжээ.
- Газрын эзэд улсыг удирдах ажилд оролцох боломжтой болж хааны дэргэд "Хааны Их Хурал"-ыг байгуулах үндэс тавигджээ.
- Улсыг удирдаж байгаа хүмүүс насан туршдаа бус, харин ард түмний итгэлийг хүлээсэн тэр хугацаанд л төрийг удирдах болжээ.
- Бүх хүмүүс хаанд бус, хуульд захирагдах болжээ.
- Бүх хүмүүс тэгш эрхтэй байх тийм шударга нийгэмд амьдрах ёстой гэсэн санаа бий болжээ.





Парламент гэдэг үг "parler" буюу "ярих, хэлэлцэх" гэсэн утгатай франц үгнээс гаралтай.



1295 онд Эдуард хаан парламентад Английн гүн, ноёдоос гадна тайж, хотын иргэдээс сонгож оролцуулах болсноор **Төлөөллийн парламент** бий болжээ.


I-р Эдуард хаан (1272-1307)

Энэ цагаас хойш парламент нь зөвхөн язгууртнуудаас бүрдсэн, тэдний эрх ашгийг хамгаалдаг бус, харин ард түмний төлөө ажилладаг, ард түмнээс сонгогдсон **ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГА** болон хөгжиж иржээ.



Хаан ганцаараа улсыг удирдахаа больж, газрын эзэд буюу баронуудаас бүрдсэн Хааны Их Хурал улсын хэргийг удирдахад оролцох болжээ.

Магна Хартыг баталснаас 30 жилийн дараа буюу 1246 онд Эзэн хаан улсын хэргийг удирдахад туслах **Үүрэгтэй Хааны их хурлыг "Парламент"** гэж нэрлэх болжээ. Тухайн үед энэ хуралд ард түмнээс сонгогдсон төлөөлөгч хараахан байдаггүй байв.



Парламентын зорилго нь ард түмний нийтлэг хүсэл сонирхлыг төлөөлөх юм.

Энэ нь **сонгуулиар** хэрэгжинэ. Сонгуулиар сонгогдон бүрэлдэж байгаа парламент нь хүйс, хэл, шашин, үндэс угсаа, мэргэжил болон улс төрийн **олон янзын** бүлгийн төлөөллийг багтаасан байвал төлөөллийг хангасан парламент болж чаддаг. Ингэснээр парламент нь хууль, бодлогын асуудлыг жирийн иргэдийн ялгаатай амьдрал, туршлагын үүднээс олон талаас нь хэлэлцэж шийдвэрлэх боломжтой болдог.



Манай улсын парламент буюу Улсын Их Хуралд хуульч, эдийн засагч, эмч, багшаас гадна дуучин, тамирчин гээд янз бүрийн мэргэжилтэй хүмүүс гишүүнээр сонгогдсон байдаг шүү дээ. Энэ нь парламент янз бүрийн хүмүүсийн төлөөллийг багтаасан байдагтай холбоотой юм байна.

Би урд нь парламентын гишүүнээр зөвхөн хуульч хүмүүс л сонгогдох ёстой гэж бодож байсан юм. Нээрээ эрэгтэй, эмэгтэй, мөн янз бүрийн мэргэжилтэй хүмүүс байж болох юм байна.




Парламентын үндсэн үүрэг нь ард түмнийг төлөөлөхөөс гадна хууль тогтоох (батлах), баталсан хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавих юм.



1 АРД ТҮМНИЙГ
ТӨЛӨӨЛӨХ



2 ХУУЛЬ
БАТЛАХ
/ТОГТООХ/



3 ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ

Парламент нь эдгээр үндсэн үүргээ хэрэгжүүлэхдээ нийт иргэн, улсынхаа эрх ашгийг эрхэмлэн баримталж ажилладаг.



ПАРЛАМЕНТ БОЛ НИЙТ ИРГЭДИЙН НИЙТЛЭГ АШИГ
СОНИРХЛЫГ ХАМГААЛЖ, ТЭДНИЙГ ТӨЛӨӨЛЖ, ХУУЛЬ
ТОГТООХ БАЙГУУЛЛАГА ЮМ.

ҮҮНИЙГ МЭДЭХ Үү?

Парламентыг бүтцийн хувьд нэг танхимтай, эсхүл хоёр танхимтай (дээд, доод танхим) гэж ангилна.

6

1

Нэг танхимтай парламент нь тухайн улсын нийт иргэдийн төлөөллөөс бүрдэнэ.

2

Хоёр танхимтай парламентын доод танхим нь нэг танхимтай парламенттай ижил тухайн улсын нийт иргэдийн төлөөллөөс бүрдэнэ. Харин дээд танхим нь газар нутаг, муж улсуудын төлөөллөөс бүрдэнэ. Жишээ нь: АНУ-ын парламент буюу Конгресс 2 танхимтай бөгөөд дээд танхимиyg Сенат, доод танхимиyg Төлөөлөгчдийн танхим гэнэ. Сенат нь АНУ-ын мужуудын төлөөллөөс бүрддэг бол Төлөөлөгчдийн танхим нь нийт иргэдийн төлөөллөөс бүрдэнэ.



ДЭЛХИЙ ДЭЭР

200

ГАРУЙ УЛС БИЙ

193

УЛС ПАРЛАМЕНТТАЙ

79

2 ТАНХИМТАЙ

114

1 ТАНХИМТАЙ



ТҮЛХҮҮР ҮГ



- ✓ Парламент
- ✓ Магна Харта
- ✓ Хууль тогтоох

- ✓ Сонгууль
- ✓ Төлөөлөгч



ДАСГАЛ АЖИЛ

A horizontal red wavy line is drawn across the page, consisting of several small, rounded, upward-curving segments. It is positioned in the upper portion of the page area.

1. Урьдчилан бэлтгэсэн цаасан дээр ангийнхаа Магна Хартаг бичээрэй.



2. Парламенттай холбоотой нэр томъёог олно уу!

А	Р	Т	С	Б	У	ы	Р	М	Х	С	М	Й
И	Р	М	Х	А	А	н	ы	Х	у	Р	А	Л
С	А	Д	Ф	Я	Й	ы	У	К	У	Р	Г	П
О	Б	М	Ч	У	Ж	Э	У	С	Л	М	Н	Ф
Н	ы	Б	Ж	И	Г	Х	Б	Р	Ь	Ф	А	Ө
Г	К	А	З	С	Л	П	М	Х	Т	Ъ	Х	Т
у	ъ	о	я	р	о	а	п	а	о	я	а	ь
у	й	м	в	ю	ы	р	л	г	г	м	р	в
л	п	а	р	л	а	м	е	н	т	т	т	ж
ь	з	и	ф	н	а	х	р	х	о	р	а	и
ж	ө	ю	н	о	р	ѣ	ъ	э	о	у	л	г
а	о	т	ө	л	ө	ө	л	ө	х	б	ө	ц
ө	м	а	а	ц	ъ	ѣ	д	ы	г	й	ю	л



ХЯНАЛТЫН АСУУЛТ



1. Парламент үүсч хөгжихөд Магна Хартын үүрэг, нөлөөг тайлбарлана уу.
 2. Яагаад парламентад өөр өөр хүмүүсийн төлөөлөл байх ёстой вэ?
 3. Парламентын үндсэн үүргийг нэрлэнэ үү.